

Төсөл хөтөлбөрийн хүрээнд хийсэн ажлын тайлан

- НҮБ-ын Хабитатын Монгол дахь салбараас хэрэгжүүлж буй дүүргийн 4, 5, 26, 27 дугаар хороодын нутаг дэвсгэрт “Гэр хорооллын иргэдийн үерийг тэсвэрлэх чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд хөрсний ус зайлуулах 2,2 км үерийн далан, 2 хөвд цөөрөм, 3 явган хүний гүүрний ажлыг бүрэн хийж дууссан. Үерийн хамгаалалтын трасст өртсөн 10кВ, 0,4кВ-ын цахилгааны агаарын шугамыг холбогдох байгууллагуудаас зөвшөөрөл авч зураг төслийн дагуу зөөн шилжүүлсэн. Дүүргийн Засаг даргын 2024 оны А/632, А/651, А/724, 2025 оны А/125, А/325 дугаар захирамжуудаар нийт 50 иргэний 24,974 м2 газрыг 4,423,856,000 төгрөгийн нөхөх олговрыг дүүргийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэж чөлөөлөлт хийгдсэн.

- **"Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр":**

Төслийн 2 дугаар үе шат үе “Баянхошуу дэд төв”-ийн ны хүрээнд:

Баянхошуу дэд төвд 5 нийгмийн барилга байгууламж, 2 инженерийн барилга байгууламжийн ажил гүйцэтгэхээс 5,8 км дулааны шугамын ажил бүрэн дууссан. УДДТ-2, дулааны насос станц 1, хаалттай дэд өртөө 2, 3.4км дулааны шугам, 2.4 км усан хангамж, 0,3м бохирын шугамын ажлын явц 91,3%-тай байна.

- Аврах гал унтраах 29 ангийн барилга-60.2
- Спорт цогцолбор-85
- Баянхошуу цэцэрлэгт хүрээлэн-90
- Олон нийтийн хөгжлийн төв-38

240 хүүхдийн цэцэрлэгийн барилга ажлын явц-42.3 хувьтай явж байна.

Төслийн 3 дугаар үе шат буюу “Толгойт дэд төв”-ийн хүрээнд:

- Авто зам 6,02 км
- Дулааны шугам 6,1км
- УДДТ 5ш
- Бохир усны шугам 8,9км
- Цахилгааны шугам 56,4км
- Холбооны шугам 6,7км
- Цэвэр усны шугам 7,5км-33.3 хувь
- Үерийн хамгаалалтын суваг 6,9км-95 хувь
- Сургалтын төвийн барилга угсралт-96.3 хувь
- 42 дугаар сургуулийн барилгын өргөтгөл-60,6 хувь
- Мэдээлэл холбооны төв-100 хувь
- 4га газрын тохижилт, ногоон байгууламж-15 хувьтай ажил хийгдэж байна. Тус бүтээн байгуулалтын газрын нөлөөлөлд нийт 530 айл өрхөд өртсөнөөс 522-д нөхөн олговрыг олгож, газар чөлөөлөлт 98.5% -тай байна.

- Монголын мянганы сорилтын сангаас хэрэгжүүлж буй "Газар доорх усны баруун шинэ эх үүсвэр" төсөл нь 350 сая ам/дол-ын санхүүжилттэй 2021-2025 онд дүүргийн 32 дугаар хорооны нутаг дэвсгэрт хэрэгжиж байна. Тус байгууламж нь өдөрт 105000м3 усыг цэвэршүүлэх хүчин чадалтай бөгөөд ус гүн цэвэршүүлэх байгууламжийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 99.5, ус дамжуулах хоолой угсралтын ажил 100 хувь хийгдсэн. Инженерийн шугам сүлжээний ажил дууссаны дараа улсын комисст хүлээлгэн өгнө.

- Дэлхийн банкны санхүүжилт - 41 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Өнөр хорооллын гудамжийн 2.8 км замыг цогц гудамж зам болгон хөгжүүлэх төслийн хүрээнд 1 дүгээр байрны араас Саппоро хэсгийн уулзвар хүртэлх, 1 дүгээр байрнаас 11 дүгээр байр хүртэлх хэсгийн ус зайлуулах байгууламжийн угсралтын ажил, авто замын суурь, хучилтын ажил, явган замын ажил, дугуйн замын хучилтын ажил, Мөнгөнгүүр эмнэлгийн

ард байрлалтай 86 авто машины зогсоол, ус зайлуулах байгууламжийн ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Ажлын явц 35% тай байна.

Үйлдвэрчний эвлэлийн гудамжийг цогц гудамж зам болгон хөгжүүлэх ажлын хүрээнд Ханын материалын уулзвараас Баянхошууны тойрог уулзвар хүртэлх авто замын ус зайлуулах байгууламжийн угсралтын ажлыг бүрэн, 1.3 км хэсэгт авто замын суурийг сольж, хучилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийт ажлын явц 30% тай байна. Төслийн гүйцэтгэгч Макс роуд ХХК, Арж капитал ХХК түншлэл.

- Шинжлэх ухааны академийн санаачилгаар Солонгос улсын 5,5ам/долларын буцалтгүй тусламжаар хөрсний бохирлыг бууруулах зорилго бүхий “Улаанбаатар хотын гэр хорооллын ариун цэврийн байгууламжийн асуудлыг шийдвэрлэх төсөл” хэрэгжиж байна. Төслийн хүрээнд урьдчилан цэвэрлэх байгууламж-1, бохирын машин-2, 740 орчим айлын 00-ыг шинэчлэх ажил хийгдэхээр төлөвлөгдсөнөөс 24 дүгээр хорооны голын гольдрол дагасан 746 айлын 00-ыг хөрсөнд шингэхгүй эко болгон шинэчлэх ажил хийгдсэн. Зөөврийн бохир усны урьдчилан цэвэрлэх байгууламж барих газрын асуудал олон удаа өөрчлөгдөж байгаагаас төслийн хэрэгжилт дахин 1 жилээр сунгагдсан.

ГЭР ХОРООЛЛЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТ

5, 9, 20, 23, 34 дүгээр хороодын нутаг дэвсгэрт гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн ажил хэрэгжиж байна.

- Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хороонд хэрэгжих Ханын материал орчмын 3,000 айлын орон сууцны төсөл хэрэгжихээр шав тавьсан. Нийт талбайн 50%-д нийтийн эдэлбэр, зогсоол, ногоон байгууламж төлөвлөсөн бөгөөд “20 МИНУТЫН ЖИШИГ ХОРООЛОЛ” болж хөгжих юм. Төслийн хүрээнд эхний ээлжид 12.6 га талбайд 1,800 айлын орон сууц барих бол хоёрдугаар ээлжид 1,200 айлын орон сууцны төсөл хэрэгжүүлэхээр зорьж байна. Гүйцэтгэгч “Материалимпекс” ХХК.

- - 360 хүүхдийн ортой цэцэрлэг
- - 400 хүүхдийн суудалтай сургууль
- - Гэрэлт гудамж - /7,800 м.кв/
- - Оффис, сургалт хөгжлийн төв - /20,100 м.кв/
- - Үзвэр үйлчилгээтэй спорт төв - /23,700 м.кв/
- - Худалдаа, үйлчилгээний талбай - /4,370 м.кв/
- - Дулаан гарааш /ногоон байгууламж, тоглоомын талбай/ - /25,790 м.кв/
- - Гадна ил зогсоол - /7,375 м.кв/
- - Дугуйн зам, гүйлтийн зам төлөвлөгдсөн.

- 9 дүгээр хорооны нутаг дэвсгэт хэрэгжиж буй Ногоон орон сууц хөтөлбөрийн хүрээнд 5,6 га талбайд нийт 462 айлын орон сууц баригдахаас Б15 талбарт хэрэгжиж буй 4 блок 110 айлын ногоон орон сууцны барилга ашиглалтад орсон.

Б13-1 талбарт баригдаж буй 150 айлын барилга угсралт 70 хувь, Б13-2 талбарт баригдаж буй 76 айлын орон сууцны барилга угсралт 56 хувьтай хэрэгжиж байна. 2025-2030 онд 20га талбайд 8, 9 дүгээр хороодод Баянхошуу дэд төвийг түшиглэн 5-16 давхар 2354 айлын орон сууцны барилгыг барих төлөвлөлтэй байна.

- 20 дугаар хороонд 2.1 га талбайд 1 давхар 11 дан байр /108 өрх/-ыг буулгаж дахин төлөвлөн барилгажуулах ажлын гүйцэтгэгчээр “Тулгуур түмэн тулга” ХХК шалгарч, нийт 11 байраас 5 буулгаж, 16 давхар 8 блок орон сууц, 1 цэцэрлэг, үйлчилгээний төв баригдахаар төлөвлөгдсөн.

1, 2 дугаар блокын барилгын угсралтын ажил 80 гаран хувьтай, 3, 4 дүгээр блокын барилгын цутгалт, карказ угсралтын ажил дууссан 4 байрны гүйцэтгэл 60 орчим хувьтай

байна. Гадна шугам сүлжээний ажлын гүйцэтгэгч Вилл вест ХХК нь Гадна шугам сүлжээний өргөтгөл шинэчлэлтийн ажлын явц 80 орчим хувьтай байна.

- Дүүргийн 34 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 99,920 м2 газарт "Орлогод нийцсэн орон сууцны төсөл"-ийн хэрэгжүүлэгчээр "Сайхан төмөрт" ХХК шалгарсан. Тус хорооллынтөлөвлөлт:

- Зоорьтой 9 давхар, 13 блок 1764 айлын орон сууц
- 11 блок амины сууц /single house, town house/ 16
- 320 хүүхдийн сургууль
- 200 хүүхдийн ортой цэцэрлэг
- Ногоон байгууламж

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар ус, цахилгаан, дулаан хангамж, ариутгах татуурга, цэвэр, бохир усны шугамын ажлууд хийгдсэн. Эхний 2 барилга нь зоорийн давхар болон 6 давхар хүртэлх барилга угсралтын ажил хийгдсэн.

- Баянголын аманд 10га талбайд БНСУ-ын Эксим банкны жилийн 0.15 хүүтэй 114.7сая ам/дол-ын зээлийн санхүүжилтээр орлогод нийцсэн эрчим хүчний хэмнэлттэй, 10 давхар, 14 блок 2007 айлын орон сууцны хорооллыг барих төлөвлөлттэй. Төслийн ерөнхий гүйцэтгэгчээр "Ил сонг" ХК шалгарч, барилга угсралтын ажлын гүйцэтгэл 5, төслийн нийт гүйцэтгэл 25 хувьтай явагдаж байна.

АШИГЛАЛТЫН ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ БАРИЛГЫГ БУУЛГАЖ ДАХИН БАРИЛГАЖУУЛАХ АЖИЛ

Дүүргийн хэмжээнд 7 хорооны 29 ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилга байна. Үүнээс 2 хорооны 5 байршилд гүйцэтгэгч сонгон шалгарч, 6 хорооны 23 байршилд гүйцэтгэгч сонгон шалгаруулах эрхийг нийслэлийн Засаг даргаас "Улаанбаатар орон сууцжуулалт" ХХК-д шилжүүлсэн байна.

18 дугаар хороонд төсөл хэрэгжүүлэгч "Хур алтан өргөө" ХХК нь багц 2 хүрээнд 5 байрыг буулган, барилгын ажлыг эхлүүлсэн ч барилга угсралтын 13 дугаар давхарт, ажил удааширч зогссон. Станцын 4 дүгээр байрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчийн эрхийг нийслэлийн Засаг даргын захирамжаар цуцалж, дахин барилгажуулах ажлыг зохион байгуулахыг "Улаанбаатар орон сууцжуулалт" ХХК-д даалгаж, тендерт "Гартаам агат" ХХК шалгарч, барилгын ажил 60 орчим хувьтай байна. Гадна шугам сүлжээний ажлыг "Н Эй Би Групп" ХХК гүйцэтгэж, ажлын явц 80 орчим хувьтай.

19 хорооны ашиглалтын шаардлага хангахгүй 3-20 дугаар дан байрны тендер сонгон шалгаруулалтаар төслийг хэрэгжүүлэхээр Очир бумбат констракшн ХХК шалгарсан. 1 давхар нь үйлчилгээний талбай бүхий 1 блок 16 давхар 132 айлын орон сууцны барилгын төлөвлөлттэй. Барилга угсралтын ажил 13 давхарт явагдаж байна.

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТЭС